



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР,
БОЭТ, ТӨВ ЭМНЭЛЭГ, ТӨРӨЛЖСӨН
МЭРГЭЖЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ
МЭРГЭЖЛИЙН ТӨВИЙН ДАРГА НАРТ

2019.03.13 № 71982
танай _____-ны № _____-Т
Төлөвлөгөө хүргүүлэх тухай

2019 оны Олон улсын сувилагчдын өдөр тэмдэглэх тухай Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/95 дугаар тушаалыг үүгээр хүргүүлж байна.

Үйл ажиллагаандаа тусган, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, холбогдох тайланг заасан хугацаанд Эмнэлгийн тусламжийн газарт газарт ирүүлнэ үү.

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАНҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.БАТТҮВШИН



0811119



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

Олон улсын сувилагчдын өдөр
тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдөр тохиох Олон улсын сувилагчдын өдрийг “Нийгмийн эрүүл мэндэд сувилагч бидний оролцоо” уриан дор тэмдэглэх ерөнхий удирдамжийг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. 2019 оны олон улсын сувилагчдын өдрийн улсын нэгдсэн дарга хэмжээний ерөнхий зохион байгуулалтыг хангаж, хамтарч ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлэг /Г.Баясгалан/-т даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар (М.Баттүвшин)-т үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 03 сарын 11-ны
өдрийн 4/дугаар тушаалын хавсралт

**ОЛОН УЛСЫН СУВИЛАГЧДЫН ӨДРИЙГ "НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД
СУВИЛАГЧ БИДНИЙ ОРОЛЦОО" УРИАН ДОР ТЭМДЭГЛЭХ
ЕРӨНХИЙ УДИРДАМЖ**

1. Нийтлэг зүйл.

Эрүүл байх нь хүний амьдралын хамгийн үнэ цэнэтэй баялаг мөн бөгөөд ДЭМБ-ын тодорхойлсноор: "Эрүүл мэнд-бол амьдралын чанарын тусгал бөгөөд өвчнөөс урьдчилан сэргийлэх, амьдарч буй орчин, хэв маяг, дадал зуршлагаас шалтгаалах өргөн хүрээтэй ойлголт" мөн гээд энэ хүрээнд дараах 5 зорилтыг дэвшүүлэн тавьсан. Үүнд:

- Бүх нийтийн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагыг хангах, япангоя зах хязгаар, алслагдсан бүс нутгийн хүн амыг аюулгүй амьдрах орчин, хоол хүнс, цэвэр ундны усаар хүрэлцээтэй хангах,
- Орчны бохирдол, сөрөг нөлөөлөл, орчноос шалтгаалсан эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах,
- Биологийн болон нийгмийн хүчин зүйлээс шалтгаалсан цочмог болон удаан явцтай халдварт өвчний хяналт, тандалт, сэргийлэлтийн арга хэмжээнд түлхүү анхаарах,
- Зорилтот бүлэг буюу эмэгтэйчүүд хүүхэд, өндөр настны амьдралын чанарыг дээшлүүлэх,
- Хот, сууринд оршин суугчдын эрүүл мэндийн асуудал зэрэг болно.

Манай улсын хувьд энэ хүрээнд малчид болон хөдөөгийн иргэдийн эрүүл мэнд, эрүүл амьдрах орчны асуудал бөгөөд мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгааг хүргэх гар угаалт, усанд орох, хувийн ариун цэвэр сахих асуудалд сачал дэвшүүлж, тодорхой загвар нэвтрүүлэх шаардлагатай байна.

2. Зорилго:

Хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад сувилагчийн оролцоог нэмэгдүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.

3. Зорилт:

1. Иргэдийн эрүүл амьдрах орчныг дэмжсэн аяныг орон нутагт зохион байгуулах, (Малчдын гар угаах цомог, загварыг нэвтрүүлэх),
2. Үйлчлэх хүрээний айл өрхүүдийн эрүүл амьдрах хэв шинжид үнэлгээ хийж, сургалт, сурталчилгаа зохион байгуулах,
3. Аймаг, орон нутгийн түвшинд үзүүлж байгаа сувилахуйн тусламж, үйлчилгээтэй танилцах, албадыг чадавхижуулах сургалт, үзүүлэх сургууль, сувилахуйн эмнэл зүйн хэлэлцүүлэг зохион байгуулах;
4. Сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээний хураг зохион байгуулах.

4. Зохион байгуулагч:

- ЭМЯ, ДЭМБ
- Улсын хоёрдугаар төв эмнэлэг,
- Монголын сувилагчдын нийгэмлэг ТББ,
- "Сувилахуйн амьдрал төв" ТББ,

5. Үйл ажиллагаа, хүрэх үр дүн:

Эрүүл мэндийн байгууллагууд **"Нийгмийн эрүүл мэндэд сувилагч бидний оролцоо"** сэдвийн хүрээнд дараах нийтлэг арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд:

Нэг. Сувилагчийн нэг өдөр аяны хүрээнд эрүүл мэндийн байгууллагын түвшинд зохион байгуулах арга хэмжээ

№	Үйл ажиллагааны чиглэл	Шалгуур үзүүлэлт, хүрэх дүн	Хугацаа	Дүгнэх
Бүх шатны ЭМБ-ууд энэхүү уриан дор иргэдийн нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн доорхи ерөнхий арга хэмжээг багтаан төлөвлөж, хэрэгжүүлнэ.				
1.	Үйлчлэх хүрээний айл өрх, үйлчлүүлэгчийн эрүүл амьдралын хэв шинжид үнэлгээ хийж, сургалт, сурталчилгаа зохион байгуулах (Дундговь аймгийн үлгэрчилсэн загварыг ашиглаж болно, хавсаргаснаар)	Үнэлгээ хийж, сургалтад хамруулсан өрхийн тоо	2019 оны 3-5 сар	Авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг 2019 оны 05 дугаар сарын 01-нд Эмнэлгийн тусламжийн газарт ирүүлэх
2.	Гэр хороололд амьдарч байгаа болон малчин өрхүүдэд гар угаах үлгэрчилсэн загварыг сурталчлах, турших	Сургалт хийж, туршилтад хамруулсан өрхийн тоо	2019 оны 3-5 сар	
3.	Гэр хороололд амьдарч байгаа болон малчин өрхүүдэд ундны ус хадгалах болон зөөвөрлөх стандартын шаардлага хангасан савтай болгох хөдөлгөөн өрнүүлэх	Үнэлгээ хийж, сургалтад хамруулсан өрхийн тоо	2019 оны 3-5 сар	
4.	"Нийгмийн эрүүл мэндийн сувилахуй" сэдвийн хүрээнд сувилагчдын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах, - байгууллагын түвшинд шалгарсан илтгэлүүдээс аймаг, нийслэлд шалгаруулж, - төв, эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүдээс шалгаруулж тэргүүн байранд шалгарсан нэг бүтээлийн товчлол, - 2,3-р байрт шалгарсан бүтээлүүдийн ханын илтгэлийг ирүүлэх	Байгууллагын түвшинд шалгарсан илтгэлүүдээс аймаг, нийслэлд шалгаруулан дүгнэсэн байна	2019 оны 3-5 сар	
5.	Иргэд, олон нийтэд зориулан "Өөрийгөө сувилах нь" гар утасны аппликэйшн, гарын авлага хийж сурталчлах, үзүүлэх сургалт зохион байгуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх - Өмнөговь аймгийн ЭМГ-ын дэргэдэх сувилахуйн алба, - Монголын сувилагчдын нийгэмлэг ТББ, - "Сувилахуйн амьдрал төв" ТББ	Иргэд, олон нийтэд зориулан "Өөрийгөө сувилах нь" гар утасны аппликэйшн, гарын авлага гарсан байна	Жилдээ	2019 оны 11 сарын 1-ний дотор Эмнэлгийн тусламжийн газарт ирүүлэх

Хоёр. Олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэх улсын нэгдсэн арга хэмжээ

Хаана: Улаанбаатар хотод

Хугацаа: 2019 оны 5 сарын 08-12нд

1. “Нийгмийн эрүүл мэндийн сувилахуй сэдэвт” сувилагчдын эрдэм шинжилгээний хурал, 3 дахь шатны шалгаруулалт,
2. Эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны олон улсын сувилагчдын өдөр тэмдэглэх хүрээнд хийсэн ажлын ханын самбар тайлан, биет үзүүлэн,
3. **“Нийгмийн эрүүл мэндэд сувилагч бидний оролцоо”** сэдэвт нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн сургалт
 - Харвалт шигдээсийн үед үзүүлэх анхны тусламж, иргэдийн үүрэг
 - “Иргэн би аврагч” амилуулах суурь тусламжийн үзүүлэх сургууль

Хяналт, үнэлгээ.

1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дэргэдэх сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний албад харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж, дүгнэнэ.
 2. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн сувилахуйн албаны дарга нар байгууллагынхаа хэмжээнд арга хэмжээг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж, дүгнэнэ.
 3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн сувилахуйн албаны дарга нар зохион байгуулсан үйл ажиллагааныхаа зорилго, зорилт, хүрсэн үр дүнг тодорхой тусгасан товч тайланг, “А4” хэмжээний нэг хуудаст багтаан Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт 2019 оны 05 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ.
- 4. Үйл ажиллагааг дүгнэх.**
1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дэргэдэх сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний албад харьяа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг шалгаруулан тэргүүний баг, хамт олныг нэгээс гуравдугаар байр эзлүүлэн цалингийн 25 хүртэлх зувиар шагнаж урамшуулах арга хэмжээг авсан байна.
 2. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн сувилахуйн албаны дарга нар байгууллагынхаа тэргүүний тасаг, баг, хамт олныг шалгаруулан нэгээс гуравдугаар байр эзлүүлэн цалингийн 25 хүртэлх зувиар шагнаж урамшуулах арга хэмжээг авсан байна.
 3. Улсын хэмжээний нэгдсэн арга хэмжээг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах хэлбэрээр зохион байгуулж, хүн амд мэдээллийг ил тод хүргэх арга хэмжээг авна.
 4. Улсын хэмжээнд тэргүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байгууллагыг урамшуулна.